

Хэсэг 16

Монголын бурханы шашин: Өнгөрсөн ба эдүгээ

Түүхийн солбицол дахь соёлыг тунгаан харахад

Гленн Муллин

Редакторын тайлбар: Авьяаслаг зохиолч, Төвдийн бурханы шашны ном бүтээлийг орчуулагч, Монголд нэлээдгүй хэдэн жил амьдарсан Гленн Муллин Монголын эзэнт гүрний өмнөх үеэс өнөөг хүртэлх Монголын бурханы шашны тухай өргөн хүрээтэй, тодорхой өгүүлсэн байна. Тэрбээр Монголын соёл ба бурханы шашны гурван цэцэглэлтийн давалгаа ба дөрөвдөхь болгон XVII зууны дунд үе дэхь Занабазарын үеийг авч үзэж тодорхой дүн шинжлэл өгчээ. Тэрбээр Монголын бурханы шашны түүх өмнөх үеийн үзэл суртал, Оросын мөн зарим үед Хятад, Өрнийхний судалгаагаар гажуудаж, буруу мэдээлэгдэн, ач холбогдлыг нь бууруулж байсныг онцлон дурдсан аж. Муллин түүхийн өргөн хүрээ хэмжээнд социализм ба түүний дараах үеийн Монголын соёл, шашны байдалд үнэлэлт дүгнэлт өгч буйд түүний хандлагын онцлог оршино. Тэрбээр орчин үеийн Монголын соёлын сэргэлт, бурханы шашны дахин хөгжилтөнд учирч буй бэрхшээлийг гярхай олж харан дурдаж ялангуяа түүхэн урлаг, эд өлгийн зүйлсийг алдагдах байдал үргэлжилсээр байгаа, үүнд засгийн газрын оновчтой бодлого чухал болох, Чингис хааны түүхэн үүргийг хэт дөвийлгөснөөр бусад түүхэн зүтгэлтнүүдийн үүрэг ач холбогдлыг бууруулж буй (илэрхий түрэмгий бусаар), гадны эсвэл төрийн тусламж, туршилаганд хэт дулдуйдан өөрийн улсын санал хувилбарыг хөгжүүлэхгүй байгаа болон санхүүгийн хувьд сул бурханы шашинтнуудын үйл ажиллагааг үлэмж дэмжлэг бүхий Христийн шашныхантай харьцуулах нь алдаатай болох зэрэг олон асуудлуудыг хөнджээ. Монголын түүх, соёлыг биширэгч тэрбээр дүгнэлтэндээ сорилт бэрхшээл дунд буй Монголчууд тэдгээрийг даван туулж, өөрсдийн энэ

цаг үеийн их өвийг бий болгоно гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлжээ.

1. Оршил үг

Юуны өмнө би Монголын соёлыг гүнээ хүндэтгэдэг нэгэн болохоо хэлмээр байна. Дэлхийн соёлд нэн ялангуяа Төв болон Зүүн Азийн иргэншилд үүн дотор бурханы шашин, бөө мөргөлд сүүлийн 2000 жилийн түүхэнд Монголчууд тод томруун хувь нэмэр оруулсан.

Эртний түүхт Монголчууд их омог бардам хүмүүс байдаг. Тэдний талаар ямар нэгэн шүүмжийн үг хэлэхэд амархан эгдүүцэн гомдох нь бий. Иймээс “эрсдэлд буй улс орнууд” гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд Монголын тухай хэлэлцэх хурал нь зайрмагтсан мөсөн дээр гишгэхийн адил. Хэдийгээр ийм авч тэдгээр эрсдлүүдийн бай болохоос сэргийлэн хэлэлцэн ярилцах нь нэн чухал юм.

Энэхүү өгүүлэлгээ би бурханы шашны нөхцөл байдлын талаар тусгайлан өгүүлэх бөгөөд мөнхүү бурханы шашны ертөнцийн геополитик, улс төр-оюун санааны хүрээнд ямархуу эрсдлүүд байх талаар дурдана.

2. Орчин үеийн Монгол: нийгэм, улс төрийн зарим зүйлүүд

Хор чойнжун буюу *Хорын нутагт Бурханы шашин дэлгэрсэн* нь хэмээх Төвд-Монголын уран зохиолын нэгэн сонирхолтой төрөл бий. Энэ төрлийн олон зохиолууд байдаг. XIII-XX зууны үеийн Төвдийн эрдэмтэд Төв Азийн улсуудыг ерөнхийд нь “Хор” хэмээн нэрийдэж байсан ч энэ нь одоогийн Монгол угсаатнуудыг нэрлэж байжээ.¹ Хор чойнжун төрлийн

¹ Уг төрлөөр олон арван зохиол бүтээл байдаг бөгөөд ихэнхи зохиолуудыг Монгол лам нар төвд хэлээр туурвисан байдаг. Тэдгээрээс ихээхэн алдартай бүтээл нь Лувсан Дамдины *Хор чойнжун сэрдэв* буюу *Хорын нутагт Бурханы шашин дэлгэрсэн нь шар дэвтэр* хэмээх зохиол юм. Шинэчлэн засварласан байдлаар 1964 онд Шинэ Дели хотноо байрлах Энэтхэгийн

зохиолуудад “Монгол” гэсэн нэрийг хожмоо 19 дүгээр зууны төгсгөл үед ч гэсэн өргөн хэрэглэж байгаагүйг тэмдэглүүштэй.

Хорын нутаг нь мэдээжийн хэрэг одоогийн Монгол улсын нутаг дэвсгэрээр хязгаарлагдаж байгаагүй. Хорын нутагт Буриад, Сибирийн ихээхэн хэсэг, Өвөр Монгол, Казакстан улсын ихэнхи нутаг, Хятадын Чинхай, Шичиван, Шинжааны мөн ихээхэн хэсэг орж байв. Ерөнхийдөө Хятадын цагаан хэрмээс хойд, зүүн хойд болон баруун хойд нутгийг Хорын нутаг гэж байв. Уг шалтгаанаар би Монголчууд 1921 оныг Монголын тусгаар тогтнолын өдөр хэмээн тэмдэглэх хэрэггүй, яагаад гэвэл тэр жил Өргөөгийн улс төрийн удирдагчид Монголын түүхэн газрын дөрөвний гурвыг алдсан жил хэмээн монгол найзуудаа үргэлж цаашлуулдаг юм. Тэр үед Өргөөгийн удирдагчид Зөвлөлтийн зөвлөлгөөг дагаж тэдний цэргийн тусламжийг аван хүчирхэг болсон байв. Орчин үеийн Монголын хил хязгаарыг тогтооход Зөвлөлтүүд Монголчуудын ашиг сонирхлыг харгалзан үзээгүй нь илт юм. Жа лам Дамбийжанцан зэрэг эсэргүүцсэн хүний дуу хоолойг амийг нь егүүтгэн чимээгүй болгосон.²

Манжийн нутаг дэвсгэр мөн Хорын нутагт орж байв. Манжууд Чингис хаанд дагаар орон монгол бичгийг өөрийн бичиг болгон авсан. Гэвч далан жил Зөвлөлт Монголыг эрхэндээ байлгаж Манжуудыг “Хятад” хэмээн нэрлэсэн. Зөвлөлтийн хүч түрсэн үзэл суртал нь тэдгээр *хор* хүмүүсийг Монгол ахан дүүсээс нь салгажээ.

Хор үндэстнүүдийн (Татар-Монгол-Зүүнгар-Манж)

Соёлын Академиас фото офсет хэвлэлээр хэвлэн гаргасан.

² Жа ламыг Зөвлөлтийн үеийн Монголын уран зохиолд галзуу солиотой хүний дүрээр дүрсэлдэг. Энэ нь Зөвлөлтүүд түүнд дургүй байсны тод жишээ юм. Түүнийг хөнөөснөөс хойш түүний эсрэг үзэл суртлын кампанит ажил өрнүүлсэн. 1950, 1960-аад оны Монголын эрдэмтэд ч энэхүү сөрөг дүрээр түүнийг бичиж байсан. Үнэндээ 1921 оны гэрээ нь Өргөөгийн шинэ удирдагчдыг худалдан эс бөгөөс эрхэндээ оруулсан Орос, Хятадын тал Монголын газрыг булаан авч “орчин үеийн Монгол”-ыг үүсгэн байгуулсан гэрээ болохыг ухаарсан цөөхөн Монголчуудын нэг нь Жа лам байсан юм.

хоорондын харилцааны талаар маш бага судалгаа хийгдсэн. Байгаа судалгаа нь улс төрийн гуйвуулга, үзэл суртлаар булингартсан (Орос, Хятад эсвэл энэ хоёр дарангуйлагчийн эрхэнд орсон барууны эрдэмтдийг энд дурьдаж болно).¹

3. Бурханы шашин Монголд: Соёлын цэцэглэлт гурвантаа давалгаалсан нь

Лувсандамдины *Хорын нутагт бурханы шашин дэлгэрсэн нь* хэмээх зохиолд өгүүлснээр Бурханы шашин Хорын нутагт гурвантаа дэлгэрчээ.

Эхний дэлгэрэлт нь МЭӨ III зуун буюу Энэтхэгийн Ашока хааны үед юм. Энэ нь Хятадад Бурханы шашин дэлгэрэхээс гурван зуун жил, Төвдөд бурханы шашин багтай оршин тогтнохоос найман зуун жилийн өмнө гэсэн үг юм. Ашока хаан өөрийн бурханы шашинт эзэнт гүрний хил хязгаарыг умард зүгт тэлэн улмаар Хотан улсыг өөрийн эрхэнд авсан байна. Хотан нь Хорын буюу Монголын баруун хязгаартай хиллэх улс юм.

Хотангаас дорно зүг торгоны замын дагуу Монголын говь нутаг руу бурханы шашин аажмаар дэлгэрчээ. Лувсан Дамдин зохиолдоо Хор урьд цагт 100,000 гаруй бурханы шашны лам хуврагтай байсан гэж тэмдэглэжээ.

Бурханы шашин Монголд Чингис хаан болон удаах хаадын үед дахин дэлгэрсэн байна. Чингис хаан Төвдийн бурханы шашны Сажийн урсгалтай онцгой харилцаа тогтоосон байна. Улмаар Чингис хааны ач Хубилай хаан өөрийн Төвд багш Чойжал Пагбаар (Монголчууд Пагва лам гэж хэлдэг) өөрийн захиргаанд байсан нийт нутагт хэрэглэх хялбаршуулсан Төвд үсгийг зохиолгуулсан байна. Уг үсгийг

¹ Жишээ нь *China Marches West* хэмээх номын зохиолч Петр С. Пердье нь санаатай эсвэл санаандгүйгээр Хятадуудыг Манж, Монголчуудтай хольж солин Манж-Халх-Төвд нэгдэн Хятадыг эзлэн захирсныг “Манжууд бол Хятадууд” хэмээн буруугаар тайлбарласан.

Пагиг гэх бөгөөд дараагийн Монгол хаад хэрэглэн гурван зуун жилийн дараа дахин бурханы шашин Монголд дэлгэрэх хүртэл уг үсэг нийтийн хэрэглээнд байжээ. Аажмаар *пагиг* нь эдүгээ Монголын сүм хийдэд хэрэглэж буй стандарт Төвд үсгээр солигдсон байна.

Монголын Хятадыг захирах үе дуусан Нанкинаас үүсэн гарч ирсэн Мингийн үе эхэлж Монголчууд Цагаан хэрмээс хойших өөрийн язгуур нутаг руугаа буцжээ. Төд удалгүй нэгдсэн Монголын удирдлага задран Монголын эзэнт гүрнээс үлдсэн газар нутгийг Монголын язгууртнууд захирах болсон байна. Энэ үед Бурханы шашин ч бас Монголчуудын дунд буурсан байна.

Хорын нутагт Бурханы шашин дэлгэрсэн нь хэмээх зохиолдоо Лувсандамдин нь Монголд Бурханы шашин гуравдах удаагаа 1578 онд Алтан ханы ивээл дэмжлэгээр гуравдугаар Далай лам Монголын нутгаар аялан шарын шашин дэлгэрсэн хэмээн бичжээ. Тэр үед Далай лам Далай гэсэн нэрээр эс алдаршсан байв. Харин Жэ Тамжад Чэнба буюу “*Бүгдийг болгоогч Богд*” гэсэн алдраар Төвд болон бусад газар алдаршсан байжээ. Гуравдугаар Далай лам сахилийн нэр болох Содномжамц гэсэн нэртэй байв. Монголын өмнөд нийслэл Хөх хотод тэрээр ирэх үед Алтан хан “жамц” гэсэн үгийг Монгол хэлэнд орчуулсан байна. Ингэж Жамц гэдэг нь Далай болж Жэ Тамжад Чэнба гэдэг алдар нь “Далай лам Доржчан” болсон байна.

1921 оны гэрээгээр алдсан Хөх хот нь одоогийн Монгол улсын хот биш боловч 1580 онд гуравдугаар Далай ламд Алтан ханаас барьж өгсөн сүм одоог хүртэл Хөх хотод хэвээр байна. Мөн 1584 онд Хархоринд Халхын Автай сайн хан гуравдугаар Далай ламд барьж өгсөн Эрдэнэ Зуу хийд бараг бүтнээрээ одоо байна. Гуравдугаар Далай ламын хойд дүр Хөх хотын Монголчуудын дунд мэндэлснээр шарын шашин Монголын бурханы шашны гол урсгал болсон бөгөөд одоо ч энэ байдал хэвээр байна.

4. Монголын Бурханы шашны дөрөвдэх дэлгэрэлт

Лувсан Дамдины *Хор чойнжунд* олон зууны турш Бурханы шашны олон дамжлага Монголд дэлгэрсэн хэмээн дурджээ. Дээр дурьдсан гурван удаагийн дэлгэрэлт нь Монголын Бурханы шашны дүр төрхийг тогтооход гол үүргийг гүйцэтгэсэн нь тодорхой.

Хэдийгээр тийм боловч дөрөвдэх дэлгэрэлт нь XVII зууны дунд үед Төвдөд аялан улмаар 5-р Далай ламтай дотно харилцаатай болсон Өндөр Гэгээний үе юм. Тавдугаар Далай лам болон Өндөр Гэгээн хоёул дөрөвдүгээр Банчэн лам Лувсанчойжижалцаны шавь байсан. Төвдийн Лхас дахь тавдугаар Далай ламын засаглалыг зарим талаар загварлан сүүлд Өндөр Гэгээн Монголын “лам хаан” болсон. Эдүгээ Өндөр Гэгээнийг Занабазар гэх бөгөөд энэ алдар нь түүний сахилийн төвд нэр Ишдоржийн санскрит орчуулга болох Гяанаважра-ийн буруу дуудлага юм.

Занабазарын бүтээлүүд Хорын нутагт ихээхэн дэлгэрч түүний Монголын бурханы шашин 1921 онд коммунистууд төрийн эрхийг авахыг хүртэл дэлгэрч байсан.¹ 1928-1938 онд болсон хэлмэгдүүлэлтээр ихэнхи лам хуврагийг цаазлан хороож эсвэл цөллөгт явуулснаар бурханы шашин Монголд бууралтын үедээ орсон байна. Монголын бурханы шашинд Өндөр Гэгээн Занабазар үлэмжхэн нөлөөтэй хэмээн ярьдаг.

¹ Харамсалтай нь 1921 онд коммунистууд засгийн эрхэнд гарснаар Өндөр Гэгээний наймдугаар дүр 1924 онд сэжигтэй байдлаар таалал болсон. Дилав хутагт нэгэн хүүг тодруулан 1920-оод оны төгсгөл үеээр ширээнд залсан байдаг боловч Далай лам, Банчэн лам аль аль нь баталгаа эс өгсөн байна. Магадгүй тэд Монголыг эзэлсэн коммунизмаас эмээсэн байж магад. 1933 онд Далай лам, 1937 онд Банчэн лам таалал болсны дараа Жалцав Радэн Ринбүчи нэгэн Төвд хүүг есдүгээр Богд хэмээн тодруулсан байна. Ийнхүү хоёр хүүхэд Живзундамбын алдрыг барих болжээ. Монголд тодорсон хүү 1950, 1960-аад оны үед ЗХУ-д нас барсан гэдэг бол Төвдөд тодорсон хүүхэд Төвдөд шавилан сууж сүүлд Хятадын коммунистууд Төвдийг эзлэх үе буюу 1959 онд Төвдийн цагаачдын хамтаар Энэтхэг рүү дүрвэн гарчээ.

5. 1928-1938 оны соёлын хэмдэгдүүлэлт

1921 оноос эхэлсэн Зөвлөлтийн дэмжлэг бүхий “Орчин үеийн Монгол” нь сайн муу олон зүйлийг Монголд авчирсан. Арван жил ч эс хүрэх хугацаанд Сталин Орос орныг урьд хожид үзэгдээгүй нийтийн аллага, нийгмийн хардлага сэрдлэг, дарангуйлал болон соёлын хэмдэгдүүллийн эргүүлгэнд оруулсан. Монгол ч энэ хар үйлийн талбар болсон. Эхлэн Оросын эзэлсэн Монголын нутаг болох Буриад, Сибирь болон Тува зовлонгийн далайд унан улмаар тусгаар тогтносон Монгол улс удалгүй адил хувь заяатай учирсан байна. “Соёлын цэвэрлэгээ” гэсэн гэмгүй нэртэй энэхүү коммунист устгалаар коммунизмийн өмнөх Монголыг төлөөлөх ихэнхи зүйлийг устган хороосон. Эс хороосон хүмүүсийг Зөвлөлтийн бөөнөөр хорих лагерьт цөлжээ. Энэхүү хэлмэгдүүлэлтийн үеэр болсон аймшигт үйл явдлуудын баримт Улаанбаатар хот дахь нэгэн жижиг музейд хадгалагдан байна. Монголын Урлагийн Зөвлөлөөс хийсэн судалгаагаар энэ үед 1200 гаруй сүм хийд Монголд байсан бөгөөд тэдгээр сүм хийдийг номын сан, урлагийн бүтээл, анагаах ухааны эд хэрэглэл зэргийнх нь хамт устган үгүй хийжээ. Сүүлд Улаанбаатар хотод үзмэрийн байдлаар Гандантэгчинлин хийдийг дахин нээхийг зөвшөөрсөн байна. Коммунизмийн үед хуулийн дагуу зөвшөөрөгдсөн ганцхан хийд нь Гандантэгчинлин хийд байв.

6. Коммунизм нуран унасан нь

1989 онд ЗХУ-д коммунист засаглал нуран унасны үр дүнд Монголд улс төрийн хурдацтай өөрчлөлт гаран ардчилсан засгийн газар байгуулагдсан. Нөхцөл байдал бараг л нэг шөнийн дотор бүрэн өөрчлөгдөв. 1990-ээд оны дунд үе гэхэд ихэнхи улсын өмчийг хувьчилж гадаад оронд аялан жуулчлах дүрэм журмыг зөөлрүүлэн, хэвлэлийн эрх чөлөөг олгон төрийн ихэнхи монопол эрхийг задалжээ.

Ардчилал Монголчуудад шашны эрх чөлөөг мөн

авчирсан юм. Коммунизмийн үед Гандантэгчинлин хийд ганц зөвшөөрөлтэй хийд байсан бол ардчилал ялсанаар хүмүүс урьд байсан сүм хийдүүдийг дахин сэргээн барих болсон. Одоогоор Монголд ойролцоогоор 200 багахан хэмжээний сүм хийдүүд байна. Далан жилийн өмнө коммунистуудын устгасан сүм хийдүүдтэй харьцуулахад багахан боловч энэ нь бахархамаар эхлэл юм.

7. Сорилт хийгээд эрсдлийн хүчин зүйлүүд

Хатуу цагдалттай Зөвлөлтийн загварт коммунист цагдаа дэглэмээс нээлттэй зах зээлийн нийгэмд шилжсэнээр олон арван гайхалтай амжилтууд гарсан. Амжилтын хажуугаар мөн хүнд сорилтууд нэлээн байна. Тэдгээрээс хамгийн адармаатай төвөгтэй хүнд хэцүү заримыг дараалан дурдах нь зүйтэй болов уу.

а) Бурханы шашны урлагийн бүтээл алдагдахад капитализмийн нөлөө

Чөлөөт эдийн засгийн нийгэмд олон бэрхшээлтэй сорилтууд байгаа бөгөөд үүний нэг нь үндэсний үнэт өвийг хадгалан хамгаалах ажил юм. Соёлын хэлмэгдүүлэлтийн үед олон зүрх зоригтой Монголчууд амь насаа золин байж бурханы шашны ховор нандин шүтээнүүдийг сүм хийдийн халдлагаас авран хадгалж ирсэн. Үүний дараа Хрущевийн “зөөлөн цаг үе”-д олон тооны музей нээгдэн үндэсний урлагийн сор болсон бүтээлүүдийг хандивлахыг ард түмэнд уриалжээ. Зарим бүтээлийг хүмүүс музейд хандивласан бөгөөд ихэнхи нь хүмүүсийн гарт үлдсэн байна. Настай хүмүүс цагийн эрхээр явахад ихэнхи тохиолдолд тэд нартай адил хадгалан хамгаалах сэтгэлгүй үр ачид нь тэдгээр урлагийн бүтээл өвлөгдөн очжээ.

Хэдийгээр урлагийн бүтээлийн талаар засгийн газар хатуу дүрэм журам гаргасан боловч бурханы шашны урлагийн бүтээлийг танин мэдэх, хадгалан хамгаалах талаар цөөхөн тооны хүмүүс боловсрол эзэмшсэн нөхцөлд уг дүрэм журмыг

хэрэгжүүлэхэд нэн төвөгтэй байна. Өдөр бүр эс үнэлэгдэх ховор нандин урлагийн бүтээлүүд алдагдаж байна гэхэд бараг эргэлзэх зүйлгүй.

Хятадтай өргөн уудам нутгаар хиллэж байгаа нь томоохон бэрхшээл юм. Олон сонгодог бүтээлүүд урд хилээр урсан гарахаас гадна түүхэн байдлыг гуйвуулах гэмт хэрэг мөн гарч байна. Монголын шилдэг урлагийн бүтээлүүд Хятадаар дамжин Хонгконг-т очдог бөгөөд энд тэдгээр бүтээлийг Төвдийн урлагийн бүтээл хэмээн буруугаар тогтоодог. Сүүлийн жилүүдэд Төвдийн урлагийн бүтээл ихээхэн эрэлт хэрэгцээтэй байгаа тул ихэнхи Монголын урлагийн бүтээлийг Төвдийн урлаг хэмээн борлуулдаг. Урлагийн түүхчдийн хувьд энэ нь үнэхээр санаа зовоосон зүйл юм. Барууны урлаг судлаачдын хувьд Монголын бурханы шашны урлаг хараахан танигдаагүй бөгөөд Монголд энэ урлагийнхаа талаар мэдэх хүн бараг үгүй.

б) Засгийн газар

1930-аад онд Монголын засгийн газар 1,250 гаруй сүм хийдийн ихэнхийг эвдлэн сүйтгэж урлаг, уран зохиолын үнэт бүтээлүүдийг хулгайлсан. Зөвлөлтийн дэглэм унасаны дараах Монгол улсын засгийн газар тэдгээр сүм хийдийг сэргээн босгоход багахан тусламж үзүүлсэн бөгөөд бараг үгүй гэхэд болно.

Сэргээн босгох ажилд багахан хэмжээгээр туслахын сацуу эсрэгээрээ сэргээх ажлыг эхлүүлэн хөрөнгө босгож буй лам нарыг албан татвараар даран уг ажилд нь учруулж байна. Зарим талаар маргаантай боловч нэгэн хийдийн хамба лам надад аминчилан хэлэхдээ ямар ч санхүүжүүлэлтийн сан босгосон долоон төрлийн албан татвар ногдуулдаг тул эцсийн эцэст босгосон хөрөнгийн бараг 30%-тай л хоцордог юм гэсэн. Ерөнхийлөгч асан Энхбаяр нэгэнтээ үнэн байдлыг хэлэхдээ тэрээр тэдгээр албан татваруудыг үгүй болгохоор олон давхар дамжлага бүхий төрийн албатай тэмцэлдсэн тухайгаа хэлсэн.

в) Коммунист үзэл суртлын үлдэгдэл Монголын бурханы шашны түүхийг гуйвуулдаг

Коммунист засгийн газар нийгмийн шинжлэх ухааныг улс төрийн зэмсэг болгон үзэл суртлын үйл ажиллагааны нэгэн хэсэг болгож байсан. Ийм учир шалтгаанаар далан жилийн үзэл суртлын ачаанд Монгол сөхөрч байна. Үзэл суртал нь сэхээтэн ер нь нийтийн сэтгэхүйд гүн гүнзгий шингэсэн.

Нэгэн жишээ нь алдарт Говийн ноён хутагт Данзан Равжаагийн (1803-1856) тухай түүхэн гуйвуулга болно. Коммунистууд 1930-аад онд Сайншанд хоттой ойролцоо орших түүний хийдийг нураан устгаж 1940-өөд онд түүний талаар элдэв муу үгийг тараажээ. Харин 1950-аад оны үед түүний алдар нэрийг улс төрийн зорилгоор хэрэглэхийн тулд түүнийг тухайн үеийн нийгмийн эсрэг тэмцэгч пролетари улааны шашны лам байсан мэтээр дүрслэх болсон байна. Өнөөдөр ихэнхи Монголчууд түүнийг улааны шашны лам байсан гэж боддог. Үнэн байдал үүнээс тэс өөр юм. Ноён хутагт Данзан Равжаа бол Занабазар, тавдугаар Далай ламын үед амьдарч байсан шарын шашны Брайбун Гоман дацангийн ламын хойд дүр Ноён хутагтын тавдугаар дүр юм. Тэрээр өөрийн ном бясалгалдаа олон урсгалын дамжлагын номыг анхааран авдаг байжээ. Хэдийгээр тийм боловч Данзан Равжаагийн үндсэн багш нь шарын шашны тэргүүн арван ламын нэг болох Манжийн хааны багш дөрөвдүгээр Жанжаа хутагт байв. Түүнийг улааны шашны лам хэмээн дүрслэх нь цэвэр үзэл суртал юм.

АНУ-ын Нью-Йорк хотноо байрлах Рубины Музейн ажилтан Жефф Ватт хоёр жилийн өмнө Монголд ирэн Хамрын хийд орсон. Ирэхээсээ өмнө тэрээр Данзан Равжаа бол улааны шашны томоохон лам бөгөөд түүний хийдэд улааны шашны урсгалын бурхан шүтээн байдаг гэж дуулсан байлаа. Ватт бол дэлхийн шилдэг Бурханы шашны тиг зургийн мэргэжилтэн билээ. Харин тэрээр Хамрын хийдэд очоод улааны шашны

гэгдэх бурхан шүтээнүүд нь үнэндээ Лхас хотод байрлах шарын шашны Сэра хийдийн уламжлалын дагуу бүтээсэн бурхад болохыг хараад гайхсан.

Энэ мэтийн түүхийг гуйвуулсан зүйлүүдийг Монголын сэхээхэн болон олон нийтийн ойлголтоос түгээмэл харж болно. Ийнхүү түүхийг гуйвуулах байдал 1950, 1960-аад оноос коммунист үзэл суртлаар эхлэн тухайн үеийн нам, засгийн байр суурийг ягштал дагах Монгол эрдэмтдийн зохиол бүтээлд бүрэн шингэсэн байна.

Өөр нэгэн жишээ нь Манж, Төвдийн эсрэг зөвлөлтийн суртал ухуулга юм. Хэдийгээр Манж-Халх-Төвдийн холбоотны мөн чанарыг бүрэн дүүрэн эс мэдсэн ч коммунистууд Монгол нь эдийн засаг болон оюун санааны хоёр их хүчинтэй холбоотой байх нь Монголыг хараа хяналтандаа байлгахад аюул занал учруулна хэмээн үзсэн.

г) Колончиллын дараах “синдром”

Гурван жилийн өмнө миний сайн найз Проф. Боб Турмэн Монголд айлчилсан. Тэр үед ерөнхийлөгч асан Энхбаярын гэргий тэргүүн хатагтай хэвлэлийн хурал зохион байгуулсан. Хурлын үеэр Төвдийн Бурханы шашин, Монголын Бурханы шашин гэсэн асуулт тавигдсан. Учир нь Проф. Турмэн бол буддын судлалын профессор мөн Нью-Йорк хот дах Тибет Хаузын захирал басхүү алдарт монгол лам Гэвш Ванжилын үндсэн шавь нарын нэг байсан тул уг асуудлыг түүнд тавьсан юм.

Нэг сэтгүүлч түүнээс “Та Баруунд Төвдийн Бурханы шашныг дэмжиж их ажил хийсэн. Яагаад Монголын Бурханы шашны талаар их зүйлийг хийж болохгүй гэж” гэж асуусан.

Уг асуултанд Проф. Термэн “Бид баруунынхан биш харин та нар Монголчууд ихийг хийх хэрэгтэй. Монголын түүхэнд гарах дайн тулаанчид жишээ нь Чингис хааныг үргэлжид ярихын оронд харин та нар өөрсдийн түүхэн олон зуун аугаа ухаант эрдэмтэн мэргэдийг ярих хэрэгтэй. Олон

нийтийн хэвлэл мэдээллээр тэдний суу алдарыг магт. Дэлхий сонсох болно. Монголоос өөр газар хэн ч Чингис хаанд дуртай бус. Тэргэм зэмгүй олон сая хүнийг егүүтгэсэн.” гэж хариулсан. Мэдээжээр түүний энэ хариулт цугларсан хүмүүсийг цочоон алмайруулсан. Түүний хариултанд бас үнэн бий.

д) Өөрөөс илүүтэй бусдыг харах хандлага

Олон залуу лам хуврагууд Энэтхэг дэх Төвдийн сүм хийдэд суралцаж, олон ч Төвд лам Монголд ирэн ном зааж байгаа нь гайхамшигтай сайхан боловч уг байдал нь эргээд зарим аюул авчирч байна. Коммунизмийн үед Монголын бурханы шашин нуугдмал байдлаар байж олон ховор нандин дамжлага энэ байдлаар хадгалагдан ирсэн. Тэдгээр ховор нандин уламжлалт дамжлагуудыг сэргээн гаргалгүй харин ч алдан Монголын Бурханы шашныг өөрийн онцлогтойгоор сэргээн дэлгэрүүлэхэд эс хэрэглэгдэхэд санаа зовниж байна.

Олон тооны сэтгэл татам, уриалагхан Төвдийн лам нар мөн тэдний зүгээс Энэтхэгт суралцахад өгөх тэтгэлэг тусламжинд сэтгэл татагдаад далдхан байх Монгол лам нараас ном сонсох нь бага байгаа тул ийнхүү хэлж байгаа юм.

е) “Засгийн газар л хийнэ” хэмээх хандлага

Коммунизмийн үед ямарваа нэгэн гүйцэтгэвэл зохистой олон нийтийн ажлыг засгийн газрын санаачилгаар хийдэг байсан. Тиймээс ч засгийн газарын ажил л биш бол бараг хийхэд хориотой ажил болох нь тодорхой байжээ. Бурханы шашныг дахин сэргээхэд энэ хандлага мөн ихээхэн нөлөөтэй байна.

Энэхүү хандлага нь Монголын уламжлалаас хол зөрүүтэй юм. Жишээ нь Хубилай хаан олон зуун сүм хийд барин сонгодог Бурханы шашны зохиол бүтээл, урлагийн бүтээлийг тэтгэж олон мянган лам хувраг Бурханы шашинд суралцахад нь өглөгийн эзэн байжээ.

Коммунизмийн үед зөвхөн засгийн газар л олон нийтийн ажил хийдэг дүрэмтэй байв. Капитализмын үед энэ нь “Хэн

нэг нь хийг – гадны санхүүжилттэй ТББ хийх байх” гэсэн байдалтай байна.

ё) Гадны христийн шашинтнууд “сүнс худалдан авагчид”

Бурханы шашны ай сав нь өргөн уудам тул бүхий л уламжлалыг адил тэгш авч үздэг. Төвд, Монголын бурханы шашны аврал одуулах хэмээх номонд “Арван зүгийн өнгөрсөн, ирээдүй, одоогийн гэгээрсэн багш бүгдэд аврал одуулмай” хэмээх үгээр ихэнхдээ эхэлдэг. Энэ нь олон аймагт хуваагдахын уналаас сэргийлэх арга юм.

Монголын уламжлалт соёлыг сэргээхэд Солонгос, Америкаас ирсэн дэмжлэг санхүүжүүлэлт, сайн Христийн номлогчид ихээхэн саад бэрхшээл учруулж байна. Үнэндээ Бурханы шашинтнууд Христийн шашинтнуудтай эн зэрэгцэн тоглож чадахгүй юм. Коммунистууд Монголын Бурханы шашны дэд бүтцийг бүрэн устгасан. Тэд зөвхөн сүм хийд, номын сан, урлагийн бүтээлийг эвдлэн сүйтгэсэн бус нийт бурханы шашны эрдэм мэдлэг олгох институтийг нураасан. 1990 онд зөвлөлтүүд Монголыг сүйрэлд орсон эдийн засаг, дэд бүтэцтэй үлдээгээд гаран оджээ.

Энэ нөхцөлд Монголын уламжлалт оюун санааг авч явж буй хэдхэн тооны манлайлан удирдагчид сардаа л хэдэн сая долларын санхүүжүүлэл авч байгаа гадаадын номлогчидтой өрсөлдөхөд амар бус байна.

8. Дүгнэлт

Монгол нь манай тооллын өмнөх үеэс улбаалан ирсэн Буддын аугаа их түүхтэй орон. Бусад иргэншлийн адил цаг хугацааны эргүүлгэнд буурах, дэвжихийн аль альнийг нь туулан иржээ. Монгол улс эдүгээ хүнд хэцүү зөрлөг дээр зогсож байна.

Ирээдүйг зөгнөсөн Бурханы шашны эшд энэ эрин үед хэрэв бүх үндэстнүүд сайн сайхан үйлийг үйлдэх аваас 1000

жилийн алтан иргэншил бүхий Шамбалын эрин тогтоно хэмээдэг. Бурхан багшийн сургасан Цагийн хүрдэн хэмээх номонд энэхүү эшийг биелүүлэхэд умар зүгт орших орон чухал үүрэгтэй гэжээ. Цагийн хүрдний олон ч ном зохиол тэрхүү умар зүгийн орон нь Монгол хэмээн заасан байдаг.

Өөрөөр хэлбэл уг эшийн үүднээс хэрэв Монгол өөрийн оюун санааны хүч чадлаа дахин сэргээж дэлхийд тодруулан гаргаваас дэлхий ертөнц мянган жилийн алтан эринд орно. Эс бөгөөс мянган жилийн харанхуй эринд орно.

Бусад улсыг бодвол Монголчууд Цагийн хүрдэн болон Шамбалын орны тухай олон арвин ном бүтээл туурвисан. Тиймээс ч Монголчууд одоо сэргэн босч шинэ эринийг авчрах нь чухал байна.